

**“ТӨРӨӨС ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО БАТЛАХ  
ТУХАЙ” БОЛОН “ХАЛХ ГОЛ” ЧӨЛӨӨТ БҮС БАЙГУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛҮҮДИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР БАЙГАЛЬ ОРЧИН,  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 06 дугаар  
сарын 23-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн  
Г.Баярсайхан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай” болон “Халх гол” чөлөөт бүс байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2015 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлаас 2003 онд баталсан Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт 2015 онд дуусч байгаатай холбогдуулан хүнс, хөдөө аж ахуйн салбарт ойрын 10 жилд баримтлах бодлогыг шинэчлэн батлах, үүнтэй уялдуулан хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн чадавх, бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, орон нутагт боловсруулах үйлдвэрлэлийг цогцолбор хэлбэрээр хөгжүүлэх, хөдөө аж ахуйн челеөт бүсээр дамжуулан экспортлогч орон болох, хүнс, хөдөө аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилгоор уг тогтоолын төслүүдийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Д.Тэрбишдагва, О.Баасанхүү нар “Халх гол” чөлөөт бүс байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тусад нь хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг, Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан, Х.Баттулга нар 2003 онд батлагдсан бодлогын баримт бичгийн хэрэгжилт дуусч байгаатай холбогдуулан, улс орны хөгжлийн цаашдын чиг хандлага, зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан шинэ бодлого боловсруулж, өргөн мэдүүлснийг дэмжиж буйгаа илэрхийлээд энэ асуудлыг холбогдох хууль болон бодлогын бусад баримт бичгүүдтэй уялдуулан нухацтай хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналуудыг тус тус гаргасан болно.

Тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

"Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай" болон "Халх гол" чөлөөт бүс байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



С.БАТБОЛД